

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/109/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	“Анализ старт аудит” ХХК-ийн захирал: Н.Энхтуяа Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Аудитын код: БӨА-2024/109/НА-СТА-ТШЗ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.АМАНБОЛ ТАНАА

2024.02.28 № 205
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 угаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн 2023 оны жилийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Сургуулийн 2023 оны жилийн санхүүгийн тайлантай холбоотой анхаарал татах асуудал гараагүй.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402774

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>94,786,871.19</u>	<u>117,615,762.64</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,537,671.00	62,950,494.45
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	16,537,671.00	62,950,494.45
3121	Төгрөг	16,537,671.00	62,950,494.45
31211	Төрийн сангийн харилцах	16,527,671.00	62,940,494.45
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	10,000.00	10,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	78,249,200.19	54,665,268.19
351	Түүхий эд материал	500,000.00	500,000.00
35110	Тусгай зориулалттай материал	500,000.00	500,000.00
354	Хангамжийн материал	76,927,200.19	53,343,268.19
35410	Бичиг хэргийн материал	1,020,900.00	1,020,900.00
35420	Аж ахуйн материал	27,640,000.50	28,799,750.50
35440	Түлш, шатах тослох материал	27,368,660.00	5,988,380.10
35460	Хүнсний материал	20,161,139.69	16,797,737.59
35470	Бусад хангамжийн материал	736,500.00	736,500.00
35600	Мал амьтад	822,000.00	822,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,210,179,120.96</u>	<u>2,195,798,689.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,210,179,120.96	2,195,798,689.40
392	Биет хөрөнгө	2,168,277,120.96	2,152,473,450.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,284,674,912.24	2,284,674,912.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(155,575,566.07)	(198,949,589.61)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,739,354.00	89,478,353.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,021,191.00)	(38,071,668.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,658,409.41	36,658,409.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,835,997.62)	(23,954,165.66)
39217	Ном	2,637,200.00	2,637,200.00
393	Биет бус хөрөнгө	41,902,000.00	43,325,239.00
39301	Програм хангамж	550,000.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,902,000.00	41,902,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,304,965,992.15</u>	<u>2,313,414,452.04</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>209,310.00</u>	<u>209,310.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	209,310.00	209,310.00
413	Өглөг	209,310.00	209,310.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	209,310.00	209,310.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,304,756,682.15</u>	<u>2,313,205,142.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,304,756,682.15	2,313,205,142.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	135,116,466.00	135,116,466.00
51101	Өмч: - төрийн	135,116,466.00	135,116,466.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,973,711,151.11	1,982,159,611.00
51210	Өмнөх үеийн үр дүн	(381,289,688.81)	1,973,711,151.11
51220	Тайлант үеийн үр дүн	2,355,000,839.92	8,448,459.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	195,929,065.04	195,929,065.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,304,965,992.15</u>	<u>2,313,414,452.04</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,767,447,896.20	508,587,938.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,347,066,796.20	-
120	Нийтлэг татварын бус орлого	2,347,066,796.20	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	2,256,546,501.20	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	90,520,295.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,381,100.00	508,587,938.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	336,728,800.00	453,695,938.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	336,728,800.00	429,120,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	24,575,238.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,700,000.00	4,050,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,700,000.00	4,050,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	80,952,300.00	50,842,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,952,300.00	50,842,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	412,447,056.28	500,139,478.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412,447,056.28	500,139,478.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,876,412.28	468,644,006.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,054,360.00	290,055,096.55
210101	Үндсэн цалин	202,633,244.00	213,613,588.30
210102	Нэмэгдэл	45,170,982.00	63,790,960.75
210104	Урамшуулал	10,250,134.00	12,650,547.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,314,850.00	41,570,000.00
210201	Тэтгэврийн даатгал	22,679,750.00	28,395,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,646,600.00	3,340,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,043,200.00	2,672,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	449,300.00	668,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,496,000.00	6,493,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,532,760.00	49,228,614.00
210301	Гэрэл, цахилгаан	4,000.00	1,871,334.00
210302	Түлш, халаалт	27,528,760.00	47,357,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,146,623.00	-
210401	Бичиг хэрэг	166,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,588,620.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	391,503.00	-
2105	Нормативт зардал	23,100,831.00	18,480,946.60
210502	Хоол, хүнс	23,100,831.00	18,480,946.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,511,000.00	900,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,511,000.00	900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,215,988.28	68,409,349.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,390,200.00	15,866,680.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,813,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,012,788.28	52,542,669.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,570,644.00	31,495,471.40

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	7,470,744.00	9,467,905.40
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,470,744.00	9,467,905.40
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,099,900.00	22,027,566.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,099,900.00	22,027,566.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,355,000,839.92</u>	<u>8,448,459.89</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,355,000,839.92</u>	<u>8,448,459.89</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>420,381,100.00</u>	<u>433,170,700.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,050,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,050,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,050,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,050,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,381,100.00	429,120,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	336,728,800.00	429,120,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	336,728,800.00	429,120,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,700,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,700,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	80,952,300.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,952,300.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>396,348,429.00</u>	<u>371,410,876.55</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	396,348,429.00	371,410,876.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,362,694.00	360,774,476.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,054,360.00	290,429,096.55
210101	Үндсэн цалин	202,633,244.00	207,148,129.30
210102	Нэмэгдэл	45,170,982.00	70,630,419.75
210104	Урамшуулал	10,250,134.00	12,650,547.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,224,416.00	41,570,000.00
210201	Тэтгэврийн даатгал	22,589,316.00	28,395,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,646,600.00	3,340,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,043,200.00	2,672,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	449,300.00	668,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,496,000.00	6,492,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,575,000.00	-
210301	Гэрэл, цахилгаан	1,590,000.00	
210302	Түлш, халаалт	47,985,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	1,700,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,700,000.00	
2105	Нормативт зардал	20,591,248.00	13,949,050.00
210502	Хоол, хүнс	20,591,248.00	13,949,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	347,000.00	-

Аудитын код: БӨА-2024/109/НА-СТА-ТШЗ

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	347,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,511,000.00	1,849,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	728,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,511,000.00	1,120,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,359,670.00	12,977,130.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,965,200.00	11,296,130.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,394,470.00	1,681,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,985,735.00	10,636,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,885,835.00	10,636,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,885,835.00	10,636,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,099,900.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,099,900.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>24,032,671.00</u>	<u>61,759,823.45</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,495,000.00	15,347,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,495,000.00	15,347,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,495,000.00	15,347,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,495,000.00	15,347,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,495,000.00)</u>	<u>(15,347,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	16,537,671.00	46,412,823.45
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	16,537,671.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,537,671.00	62,950,494.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	135,116,466.00	195,929,065.04	-381,289,688.81		-50,244,157.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,116,466.00	195,929,065.04	-381,289,688.81	0.00	-50,244,157.77
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			2,355,000,839.92		2,355,000,839.92
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,116,466.00	195,929,065.04	1,973,711,151.11	0.00	2,304,756,682.15
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	135,116,466.00	195,929,065.04	1,973,711,151.11	0.00	2,304,756,682.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,116,466.00	195,929,065.04	1,973,711,151.11	0.00	2,304,756,682.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			8,448,459.89		8,448,459.89
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,116,466.00	195,929,065.04	1,982,159,611.00	0.00	2,313,205,142.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	519,493,100.00	492,076,867.55	501,440,400.00	411,522,310.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	519,493,100.00	492,076,867.55	501,440,400.00	411,522,310.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	508,795,300.00	481,379,067.55	485,325,100.00	400,885,910.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,216,800.00	342,800,567.55	338,034,100.00	290,429,096.55
210101	Үндсэн цалин	283,155,484.00	267,298,274.10	230,513,900.00	207,148,129.30
210102	Нэмэгдэл	76,419,645.00	63,515,126.89	93,503,200.00	70,630,419.75
210104	Урамшуулал	10,641,671.00	8,160,412.56	14,017,000.00	12,650,547.50
210105	Гэрээт ажлын хөлс	-	3,826,754.00	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,960,800.00	45,960,800.00	42,254,400.00	41,570,000.00
210201	Тэтгэврийн даатгал	31,253,200.00	31,253,200.00	28,733,100.00	28,395,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,676,900.00	3,676,900.00	3,380,300.00	3,340,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,941,500.00	2,941,500.00	2,704,300.00	2,672,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	735,400.00	735,400.00	676,100.00	668,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,353,800.00	7,353,800.00	6,760,600.00	6,492,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,575,000.00	49,575,000.00	50,793,000.00	28,464,434.00
210301	Гэрэл, цахилгаан	1,590,000.00	1,590,000.00	2,793,000.00	2,471,334.00
210302	Түлш, халаалт	47,985,000.00	47,985,000.00	48,000,000.00	25,993,100.00
2105	Нормативт зардал	20,425,200.00	20,425,200.00	22,699,600.00	13,949,050.00
210502	Хоол, хүнс	20,425,200.00	20,425,200.00	22,699,600.00	13,949,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	347,000.00	347,000.00	350,000.00	350,000.00
210604	Урсгал засвар			350,000.00	350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,872,500.00	2,872,500.00	2,470,600.00	1,849,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			1,350,000.00	728,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,872,500.00	2,872,500.00	1,120,600.00	1,120,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,398,000.00	19,398,000.00	28,723,400.00	24,274,130.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,003,300.00	17,003,300.00	27,042,400.00	22,593,130.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,394,700.00	2,394,700.00	1,681,000.00	1,681,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,697,800.00	10,697,800.00	16,115,300.00	10,636,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,697,800.00	10,697,800.00	16,115,300.00	10,636,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,697,800.00	10,697,800.00	16,115,300.00	10,636,400.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	520,593,000.00	519,493,100.00	484,612,700.00	457,935,134.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	439,640,700.00	439,640,700.00	425,670,700.00	429,120,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	439,640,700.00	439,640,700.00	425,670,700.00	429,120,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	80,952,300.00	79,852,400.00	50,842,000.00	28,814,434.00
132001	Орон нутгийн төсвөөс	80,952,300.00	79,852,400.00	50,842,000.00	28,814,434.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	8,100,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			1,350,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			6,750,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				16,537,671.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				62,950,494.45

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус сургууль нь 2023 онд “Хүүхдийн хөгжлийг дээдэлсэн жишиг сургууль болох” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Менежментийг боловсронгуй болгох бодлого баримтлах
- Боловсролын үйлчилгээг чанаржуулах
- Хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэх, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх
- Үр өгөөжтэй хяналт шалгалт хэрэгжүүлэх
- Тав тухтай орчин бүрдүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь Боловсролын Ерөнхий хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн баримтад баримтын шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сургуулийн захирлын 2022 оны 01 дугаар сарын 14-ны өдрийн А-03 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.4 сая төгрөгөөр буюу 0.37 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,537.67	62,950.49	46,412.82
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	78,249.20	54,665.27	(23,583.93)
Үндсэн хөрөнгө	2,210,179.12	2,195,798.69	(14,380.43)
Нийт хөрөнгө	2,304,965.99	2,313,414.45	8,448.46
Өр төлбөр	209.31	209.31	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,304,756.68	2,313,205.14	8,448.46
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,304,965.99	2,313,414.45	8,448.46

Мөнгөн хөрөнгө оны эцэст 62.9 сая төгрөг үлдэгдэлтэй гарч оны эхнээс 46.4 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 48.3 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс, 5.5 сая төгрөг нь үдийн цайны зардлаас, 4.4 сая төгрөг бараа үйлчилгээний бусад зардлаас, 4.7 сая төгрөг нь буса зардлаас үлдсэн мөнгө байна.

Авлагын данс үлдэгдэлгүй гарсан байна.

Бараа материал данс оны эцэст 54.7 сая төгрөг болж оны эхнээс 23.6 сая төгрөгөөр буурсан байна. Тусгай зориулалтын материал 0.5 сая төгрөг, бичиг хэргийн материал 1.0 сая төгрөг, аж ахуйн материал 28.8 сая төгрөг, түлш, шатах тослох материал 6.0 сая төгрөг, хүнсний материал 16.8 сая, бусад хангамжийн материал 0.7 сая, мал амьтад 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 14.4 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 15.1 сая, үнэ төлбөргүй авсан 22.8 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 52.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Оны эхний 0.2 сая төгрөгийн өглөг барагдаагүй, үлдэгдэлтэй гарсан байна.

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 8.4 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сургуулийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 407.6 сая, орон нутгийн төсвөөс 50.8 сая, нийт зарлагыг 458.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас сургуулийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 383.8 сая төгрөгөөр хянаж, 23,8 сая төгрөгөөр бууруулан баталсан ба төсвийн тодотголоор 66.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 450.3 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 50.8 сая төгрөгөөр баталсан ба өөрчлөлт ороогүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 450.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 50.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 501.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 382.7 сая, орон нутгийн төсвөөс 28.8 сая нийтдээ 411.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 16.5 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 411.5 сая төгрөг буюу 85.8 хувьтай байна. 62.9 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр арга хэмжээний нэр	Код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Байр ашиглалтын үйлчилгээ	80226	448.30	448.30	-	100.0%
2	Сургалт семинар	80312	224.10	224.10	-	100.0%
3	Эрүүл мэндийг дэмжих	81605	448.30	448.30	-	100.0%
4	Үдийн цай хөтөлбөр	81801	16,115.30	10,636.40	5,478.90	66.0%
5	Дотуур байрны үйлчилгээ	81806	44,037.40	25,464.04	18,573.36	57.8%
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	81816	15,466.80	15,347.00	119.80	99.2%
7	Боловсролын байгууллагын багш ажиллагс	81823	1,008.60	1,008.60	-	100.0%
8	Боловсролын стандарт сургалтын үйл ажил	81834	223,213.40	197,439.54	25,773.86	88.5%
9	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	81835	141,235.20	128,542.47	12,692.73	91.0%
10	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтыг	81844	6,750.00	2,420.53	4,329.47	35.9%
11	Сурах бичгийн түрээс	81848	1,350.00	728.60	621.40	54.0%
	Нийтлэг үйлчилгээ ОН		50,842.00	28,814.43	22,328.57	56.3%
	Нийт дүн		501,139.40	411,522.31	89,918.09	82.1%

/мянган төгрөгөөр/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж

Аудитын код: БӨА-2024/109/НА-СТА-ТШЗ

заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Сургууль нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 59.2 сая төгрөгийн бараа материал, 15.3 сая төгрөг үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Анализ старт аудит” ХХК-ны аудитор Ц.Оюунтуул, шинжээч Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг компанийн захирал Н.Энхтуяа, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Анализ старт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 412.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүнсний материал болон түлээ нүүрсний үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооллого бодитой биш байсан 47.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөн. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	47 529.9	1	23764.9	50%
Нийт дүн	2	47 529.9	1	23764.9	50%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4 058.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрч 4 058.9 мянган төгрөгийн алдааг задруулсан.Үүнд:

Мөнгөн гүйлгээний тайлан болон Сахүүгийн үр дүнгийн тайланд урсгал санхүүжилтийн орлого, туслах үйл ажиллагааны орлого дансдыг 4,050.0 мянган төгрөгөөр зөрүүлж бүртгэснийг залруусан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд элэгдлийн зардлыг 8,9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС-1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Аудитад санхүүгийн тайлангийн тодруулга, Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгыг бэлтгэж ирүүлээгүй байна.

Аудитаар нийт 58,219.3 мянган төгрөгийн зөрчил² илэрч 738.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 54,665.3 мянган төгрөгийн албан шаардлага, 2 816.0 мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 738.0 мянган төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон.Үүнд:

1.Нягтлан бодогч нь сургуулийн захирлын 2023 оны 12 сарын 22 ны өдрийн Б/30 дугаар тушаалыг үндэслэн 90.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, Б/31 дүгээр тушаалыг үндэслэн 648.0 мянган төгрөгийн урамшуулал нийт 738.0 мянган төгрөгийг илүү тооцож авсан.

Шийдвэрлэсэн нь: Илүү авсан урамшууллыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 54,665.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.Үүнд:

Сургуулийн нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд ирүүлээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрдэл дутуу, бараа материалын тайлан, бараа материалын жилийн эцсийн 54,665.3 мянган төгрөгийн тооллогын баримтуудыг дутуу ирүүлсэн, үлдэгдлийг тооцоо бодож баримтжуулаагүй, өмнөх аудитаар бараа материалын үлдэгдлийн тооллого, тооцоог бодитой хийж үлдэгдлийг баталгаажуулж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.6-д “хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврын холбогдох заалтыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

2.1.Илрүүлэлт:

Томилолтын зардлаас 2,816.0 мянган төгрөгийн томилолтыг удирдамжийг хавсаргаагүй, томилолтын тооцоо бодоогүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар олгосон байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг томилолтын удирдамж батлаж, томилолтын тооцоо бодож олгож байх,

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түрээсийн орлогын урсгал санхүүжилтээр тайлагнасан	1	4 050.0					1	4 050.0				
Элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан	1	8,9					1	8,9				
Дүн	2	4 058.9					2	4 058.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урамшуулал илүү тооцсон	1	738.0	1	738.0								
Бараа материалын тооллогын материал дутуу, бараа материалын тайлан ирүүлээгүй	1	54 665.3							1	54 665.3		

Аудитын код: БӨА-2024/109/НА-СТА-ТШЗ

Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар олгосон	1	2 816.0					1	2 816.0				
Дүн	3	58 219.3	1	738.0			1	57 481.3	1	54 665.3		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								